



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“ХҮ.1 ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын үеийн эрсдэлийг тооцоолох, санхүүгийн үр ашгийг өмнөх оноос дээшлүүлэх, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг бууруулах, үр ашиггүй зардал гаргахгүй байх, хөрөнгө оруулалт нь үр ашигтай, оновчтой, хэмнэлттэй байх зарчмыг баримтлан, гишүүдийн саналыг тусгаж, 2021 оны 12 дугаар сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзэв.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132002014

\Huraldaanii material\2021 on\2021.09.24 15-r huraldaan.docx